



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 14/262

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4, 13.1.8 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсэг, Ахмад настны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ахмад настныг нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэх, эрүүл амьдралын хэв маягт хэвшүүлэх зорилгоор "Идэвхтэй насжилт-дасгал, хөдөлгөөн" аяныг жил бүрийн 05 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: (Нийгмийн салбарын төслийн удирдагч)

Гишүүд: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

(Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга)

(Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

(Аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн захирал)

(Аймгийн ахмадын хорооны дарга)

(Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: (Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга)

2. Аяны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ